




ӨӨРТӨӨ ИТГЭ БУЯНАА



БУЯНАА БОЛ ЗОГСОЖ БАЙХДАА НОХОЙНООСО ЖААХАН Л ӨНДӨР



ОХИН БӨГӨӨД АНГИЙНХАА ХАМГИЙН НАМХАН НЬ ЮМ.




ГЭХДЭЭ ТЭР ҮҮНИЙГЭЭ ТЭГЭЖ ИХ ТООГООД БАЙДАГГҮЙ.



1




ЭМЭЭ НЬ НЭГ УДАА ТҮҮНД "МИНИЙ ОХИН ӨӨРИЙГӨӨ БИТГИЙ



ГОЛ, ӨӨРТӨӨ ИТГЭЖ ЧАДВАЛ ЧИ ДЭЛХИЙГЭЭС Ч ТОМ БАЙЖ



ЧАДНА" ГЭЖ ХЭЛЖ БАЙСАН ЮМ.



ТЭР МЭДЭЭЖ ЭМЭЭГИЙНХЭЭ ҮГЭНД ОРСОН.



2



БУЯНААГИЙН УРД ХОЁР ШҮД НЬ ТҮҮЛАЙНХ ШИГ БОЛОХООР



ЗАВСРААР НЬ БАЙНГА ААРУУЛ ОРЧИХДОГ БАЙВ. ГЭХДЭЭ БУЯНАА




ШҮДНЭЭСЭЭ ОГТХОН Ч ИЧДЭГГҮЙ. ЯАГААД ГЭВЭЛ ЭМЭЭ НЬ ТҮҮНД



“ЧИ БАЙНГА ИНЭЭМСЭГЛЭВЭЛ ДЭЛХИЙ ХҮРТЭЛ ЧАМАЙГ ДАГААД




ИНЭЭХ БОЛНО” ГЭЖ ХЭЛЖЭЭ.



ТЭР МЭДЭЭЖ ЭМЭЭГИЙНХЭЭ ҮГЭНД ОРСОН.



БУЯНААГИЙН ХООЛОЙ НЬ ЯГ Л МЭЛХИЙНИЙХ ШИГ СОНСОГДДОГ.



ГЭХДЭЭ ТЭР ҮҮНИЙГ БАС Л ТООГООГҮЙ. ЯАГААД ГЭВЭЛ



ЭМЭЭ НЬ ТҮҮНД "ЧИ ТОД ЧАНГААР ДҮҮЛЖ ЧАДВАЛ ДЭЛХИЙ



СОНСООД БАЯРЫН НУЛИМС УНАГАХ БОЛНО" ГЭЖ ХЭЛСЭН БИЛЭЭ.